



**YAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг  
хүсвэл дараах хаягаар  
харилцана уу:**

САГ-ын захирал, тэргүүлэх  
аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663  
Цахим хаяг:

Аудитын менежер: Я.Самбууням  
Утас: 260512  
Цахим хаяг:

Ахлах аудитор: Б.Долгоржав  
Утас: 261885  
Цахим хаяг:

Хаяг: Үндэсний аудитын газар  
Засгийн газрын IY байр  
Бага тойруу 6  
Улаанбаатар-46  
Монгол улс  
Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

Гүйцэтгэсэн: "Лайэн Аудит"  
ХХК-ийн аудитор: Г.Дэлгэрцэцэг  
Утас: 70126778  
Цахим хаяг: [lionaudit@yahoo.com](mailto:lionaudit@yahoo.com)

2018 оны 2 дугаар сар

**Аудитын дуусвар болсон тайлан**

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Аудит хийсэн төсвийн  
гүйцэтгэлийн тайлан



## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал тооцсон тухай
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт



## **Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хавдар судлалын үндэсний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ-2018/150/СТА-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хавдар судлалын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хавдар судлалын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг Үндэсний аудитын газрын захиалгаар 2018 оны 1 дүгээр сарын 29-нөөс 2018 оны 2 дугаар сарын 25-ны хооронд “Лайэн аудит” ХХК-ийн аудитор Г.Дэлгэрцэцэг, аудиторын туслах Ү.Цэнджав нар хийхээр төлөвлөн хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хавдар судлалын үндэсний төв 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа тус төвийн ерөнхий захирлын 2018 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 01/240 тоот албан бичгээр “Лайэн аудит” ХХК-д ирүүлсэн байна.

## **Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин**

Хавдар судлалын үндэсний төв нь Эрүүл мэндийн тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3.1-д “Эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн, эмнэлгийн тусламж үйлчилгээний, эм хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэнэ” гэж тодорхойлсны дагуу Хавдар судлалын үндэсний төв нь үйл ажиллагаагаа явуулж байна.

## **Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа**

Хавдар судлалын үндэсний төвийн эрхэм зорилго нь “Үндэсний хэмжээнд хавдрын мэргэжлийн тусламж, үйлчилгээг чанартай, ээлтэй болон тэгш хүртээмжтэй хүргэхэд оршино” гэж тодорхойлон ажиллаж байна.

Тус төв нь технологийн дэвшил, мэс заслын эмчилгээ, элэгний хавдрыг сэргээн засах, дүрс оношлогоо, аюулгүй ажиллагааны стандарт, 24 цагийн лаборатори, 21 аймаг, 9 дүүргийн хими туяа эмчилгээний чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно.

## **Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн**


Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хавдар судлалын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 19-ийг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Хавдар судлалын үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан тус төвийн ерөнхий захирлын 170 дугаар тушаалаар батлуулан 2015 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн мөрдөн ажиллаж байна. Энэхүү нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарттай нийцсэн байна. Нягтлан бодох бүртгэлийн програм нь олон улсын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нийцэж байна.

Хавдар судлалын үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/



Хавдар судлалын үндэсний төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн тооцоолохын “Acolous” програм ашиглан санхүүгийн тайланг боловсруулж гаргасан байна.

## **Тав. Материаллаг байдал**

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг 2017 оны төсвийн нийт зарлагын хэмжээг материаллаг байдлын суурь болгон авч, түүний 1 хувиар тооцон 213,792.6 мянган төгрөг гэж тооцсныг гүйцэтгэлийн шатанд 2 хувиар тооцон 427,585.3 мянган төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В-4/

## **Зургаа. Дотоод хяналтын талаар**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Тус хүрээлэнгийн ерөнхий захирлын 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/47 дугаар тушаалаар 2017 оны жилийн эцсийн тооллого явуулах ажлын хэсгийг томилон эд хөрөнгийн тооллогыг 12 дугаар сарын 18-наас 25-ны өдрүүдэд зохион байгуулсан байна.

## **Долоо. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар**

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Эрүүл мэндийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Хавдар судлалын үндэсний төвийн төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал зардалд 9,199,958.3 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 7,037,009.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоор 1,897,302.8 мянга, туслах үйл ажиллагааны орлогоор 195,950.1 мянган төгрөг нийт 18,330,221.1 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Тайлант хугацаанд бараа ажил үйлчилгээний урсгал зардалд 17,794,724.3 мянга, засгийн газрын дотоод шилжүүлгээр 68,530.2 мянга, бусад урсгал шилжүүлгээр 466,966.6 мянган төгрөг нийт 18,330,221.1 мянган төгрөгийн төсвийн зарлагын гүйцэтгэл гаргасан байна.

## **Найм. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар**

Хавдар судлалын үндэсний төв нь Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн өмч хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байхад нийцүүлэн shilendans.gov.mn сайтад батлагдсан маягт хавсралтуудын дагуу төсөв, гүйцэтгэлийн 5.0 сая төгрөгөөс дээш нийт 10,396,766.9 мянган төгрөгийн өртөг бүхий 70 худалдан авалт, бусад зарлагын гүйлгээний мэдээллийг сар бүр шилэн дансанд байршуулсан байна.

## **Ес. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар**

Төлөвлөлтийн үе шатанд аудитын 4 чиглэлээр 49 эрсдэлүүдийг тогтоон түүнд тавигдах хяналтуудыг үнэлэхэд үр нөлөөтэй байгаа тул нарийвчилсан сорилын аргаар даган мөшгих сорилыг хийлээ. Санхүүгийн аудитыг төлөвлөлтийн үе шатыг 11, гүйцэтгэлийн үе шатыг 9, тайлагналын үе шатыг 3 ажилбараар тус тус харуулав.

Үйлчлүүлэгчээс авсан тоон мэдээлэл, тайлбар, тодорхойлолт, нотлох баримтууд болон өөрсдийн хийсэн судалгаануудыг байгууллагын хард дискэнд хадгалав.

### **Арав. Гол, онцлог гүйлгээний талаар**

Хавдар судлалын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин болон бараа, ажил үйлчилгээний зардал зэрэг дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

### **Арван нэг. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар**

Аудитын явцад Хавдар судлалын үндэсний төвд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Өндөр өртөгт эм эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт хийхдээ өмнөх тендерийн гэрээг үргэлжлүүлэн хийсэн, шууд гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Босго үнэ батлах тухай” тогтоолын холбогдох заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Өндөр өртөгт эм эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг хийхдээ холбогдох эрхзүйн актыг хэрэгжүүлж ажлын талаар зөвлөмж хүргүүлэх.



2. Бэлтгэн нийлүүлэгчдээс зээлээр худалдан авсан 9,800.0 мянган төгрөгийн эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл болон бичиг хэргийн материал, хангамжийн зүйл зэрэг тооцоог авлагын дансаар дамжуулан буруу бичилт хийж бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлэх.

3. Мөнгөн гүйлгээний тайлангаар бичиг хэргийн материал худалдан авахад төлсөн мөнгө 7,601.8 мянган төгрөг байхад ерөнхий журнал болон бараа материалын тайланд 13,087.3 мянган төгрөг буюу 5,485.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журмын 2.1-т “Бүх шатны төсвийн эрх захирагч нь мөнгөн гүйлгээний тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-2 Мөнгөн гүйлгээний тайлан”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журам маягтын дагуу гаргана гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлэх.

4. Бараа материалыг орлогод авсан бүртгэлийн огноо болон бэлтгэн нийлүүлэгчийн бараа материалын зарлагын баримтын огноо зөрүүтэй 1,620.0 мянган төгрөгийн ажил гүйлгээ гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-12 “Бараа материал” болон Монгол улсын Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлэх.

### **Арван хоёр. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар**


Аудитаар Өндөр өртөгт эм эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт хийхдээ өмнөх тендерийн гэрээг үргэлжлүүлэн хийсэн, шууд гэрээ байгуулсан нь залруулах боломжгүй байна.

### **Арван гурав. Анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

### **Арван дөрөв. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд**

Хавдар судлалын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.



### **Арван тав. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**

Хавдар судлалын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 16,905.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба аудитын явцад 16,905.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулж, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар 4 зөвлөмж хүргүүлэх.

## **Арван зургаа. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Хавдар судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг Үндэсний аудитын газрын захиалгаар “Ая такс аудит” ХХК хийж 2 зөвлөмж өгснийг 100 хувь биелүүлсэн байна.

## **Арван долоо. Зөрчилгүй санал дүгнэлт**

Хавдар судлалын үндэсний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

Аудитын тайланд хавсралт материал /11 хуудас/-ыг хавсаргав.

## **АУДИТЫН ТАЙЛАНГ**

### **Хянасан:**

Аудитор

Г.Дэлгэрцэцэг

### **Бэлтгэсэн:**

Аудиторын туслах

Ү.Цэнджав

Огноо: 2018.02.25





**УАГ**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ХАВДАР СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
2017 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН**

**Менежментийн захидал**

Тэргүүлэх ач холбогдол № 1 зүйлс:

**Асуудал 1**

Худалдан авалтын талаар хуудас 3

**Асуудал 2**

Дансны бичилтийн талаар хуудас 4

**Асуудал 3**

Мөнгөн гүйлгээний тайлангийн талаар хуудас 5

Тэргүүлэх ач холбогдол № 2 зүйлс:

**Асуудал 1**

Бараа материалын орлогын талаар хуудас 6



## Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Хавдар судлалын үндэсний төвийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга нь АОУС-ын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Хавдар судлалын үндэсний төвийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмжүүд дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хавдар судлалын үндэсний төвийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.



### Аудиторын ажиглалт

Өндөр өртөгт эм эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт хийхдээ өмнөх тендерийн гэрээг үргэлжлүүлэн хийсэн, шууд гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Босго үнэ батлах тухай” тогтоолын холбогдох заалтыг зөрчсөн байна.

### Эрсдэлүүд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль зөрчигдөх.

### Зөвлөмжүүд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг дагаж мөрдөн ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.



Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг байгууллагын удирдлагад танилцуулахад хүлээн зөвшөөрсөн болно.

**Аудиторын ажиглалт**

Бэлтгэн нийлүүлэгчдээс зээлээр худалдан авсан 9,800.0 мянган төгрөгийн эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл болон бичиг хэргийн материал, хангамжийн зүйл зэрэг тооцоог авлагын дансаар дамжуулан буруу бичилт хийж бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

**Эрсдэлүүд**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын тушаал зөрчигдөх.

**Зөвлөмжүүд**

-Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” гэсэн заалт болон Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг мөрдөж ажиллах, -Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 25-ны дотор ҮАГ-т ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу  
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
01 зөрчилгүй  
САНАЛ ДҮГНЭЭТ  
Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дугаардлын байгууллагын удирдлагад танилцуулахад хүлээн зөвшөөрч аудитын явцад залруулсан болно.

### **Аудиторын ажиглалт**

Мөнгөн гүйлгээний тайлангаар бичиг хэргийн материал худалдан авахад төлсөн мөнгө 7,601.8 мянган төгрөг байхад ерөнхий журнал болон бараа материалын тайланд 13,087.3 мянган төгрөг буюу 5,485.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журмын 2.1-т “Бүх шатны төсвийн эрх захирагч нь мөнгөн гүйлгээний тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-2 Мөнгөн гүйлгээний тайлан”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журам маягтын дагуу гаргана гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

### **Эрсдэлүүд**

Мөнгөн гүйлгээний тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль, дүрэм журам, заавар зөрчигдөх.

### **Зөвлөмжүүд**

-Мөнгөн гүйлгээний тайланг Монгол улсын Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журам маягтын дагуу гаргах,  
-Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны дугаар 7 сарын 25-ны дотор ҮАГ-т ирүүлэх.

### **Үйлчлүүлэгчийн хариу**

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг байгууллагын удирдлагад танилцуулахад хүлээн зөвшөөрч аудитын явцад залруулсан болно.

**Аудиторын ажиглалт**

Бараа материалыг орлогод авсан бүртгэлийн огноо болон бэлтгэн нийлүүлэгчийн бараа материалын зарлагын баримтын огноо зөрүүтэй 1,620.0 мянган төгрөгийн ажил гүйлгээ гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-12 “Бараа материал” болон Монгол улсын Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

**Зөвлөмжүүд**

-Холбогдох хууль, дүрэм журам, зааврыг мөрдөж ажиллах,  
-Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 25-ны дотор ҮАГ-т ирүүлэх.

**Эрсдэлүүд**

Бараа материалын тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль, дүрэм журам, заавар зөрчигдөх.

**Үйлчлүүлэгчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил, дутагдлыг төрийн аудитын байгууллага ба иргэдэд танилцуулахад хүлээн зөвшөөрч зөрчигүй санал дүгнэлт аудитын явцад залруулсан болно.

**"ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ"-ИЙН  
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2017 оны 12 сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,743,205,837.79</b>	<b>1,731,489,949.28</b>
<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>АВЛАГА</b>	<b>201,572,299.42</b>	<b>46,138,909.74</b>
Байгууллагаас авах авлага	201,572,299.42	46,138,909.74
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>1,541,633,538.37</b>	<b>1,685,351,039.54</b>
Түүхий эд материал	752,006,949.13	923,195,613.32
Эм боох материал	752,006,949.13	923,195,613.32
Хангамжийн материал	789,626,589.24	762,155,426.22
Бичиг хэргийн материал	1,323,280.00	567,700.00
Аж ахуйн материал	26,924,000.00	26,924,000.00
Барилгын засварын материал	2,982,730.00	14,793,288.26
Хүнсний материал	24,063,015.00	27,938,648.90
Бусад хангамжийн материал	734,333,564.24	691,931,789.06
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>14,106,548,300.51</b>	<b>19,819,053,405.89</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>14,106,548,300.51</b>	<b>19,819,053,405.89</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>14,073,268,866.95</b>	<b>19,813,314,939.16</b>
Барилга, байгууламж	12,903,383,040.10	18,742,045,687.10
Хуримтлагдсан элэгдэл	- 7,353,219,715.61	- 7,612,853,628.95
Авто тээврийн хэрэгсэл	312,862,000.00	312,862,000.00
Хуримтлагдсан элэгдэл	- 213,111,305.76	- 250,002,972.48
Машин, тоног төхөөрөмж	17,848,623,888.03	19,758,794,773.08
Хуримтлагдсан элэгдэл	- 9,867,784,789.77	- 11,545,801,195.10
Тавилга, аж ахуйн эд хогшил	749,772,586.77	731,452,778.69
Хуримтлагдсан элэгдэл	- 396,266,825.66	- 403,431,543.86
Бусад үндсэн хөрөнгө	246,741,594.31	246,741,594.31
Хуримтлагдсан элэгдэл	- 157,731,605.46	- 166,492,553.63
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>33,279,433.56</b>	<b>5,738,466.73</b>
Програм хангамж	202,171,939.00	202,171,939.00
Хасагдуулга	- 168,892,505.44	- 196,433,472.27
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>15,849,754,138.30</b>	<b>21,550,543,355.17</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Өглөг	0.00	0.00
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>15,849,754,138.31</b>	<b>21,550,543,355.18</b>
Засгийн газрын хувь оролцоо	15,849,754,138.31	21,550,543,355.18
Өмч: -Төрийн өмч	17,025,450,888.38	17,025,450,888.38
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>- 5,935,084,718.11</b>	<b>- 232,597,781.34</b>
Өмнөх үеийн үр дүн	- 5,935,084,718.11	- 5,933,386,998.21
Тайлант үеийн үр дүн		5,700,789,216.87
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,759,387,968.04	4,757,690,248.14
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>15,849,754,138.31</b>	<b>21,550,543,355.18</b>

**01**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

**"ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ"-ИЙН  
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

2017 оны 12 сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>17,964,898,312.49</b>	<b>27,086,861,507.52</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,699,787,066.72</b>	<b>8,197,822,227.00</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,214,042,035.00	1,900,319,237.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	189,391,927.00	185,204,785.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	725,436,173.30	164,109,058.00
Бусад орлого	454,136,308.42	
Хандив тусламж /дотоод/ хөрөнгийн хандив/гадаад/	1,116,780,623.00	5,948,189,147.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>14,265,111,245.77</b>	<b>18,889,039,280.52</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,683,699,500.00	9,199,958,300.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	1,527,610,659.77	2,652,071,066.52
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	3,725,149.77	79,750,740.00
Төсвийн жилийн явцад УИХаас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУбайгуулл	-	54,493,126.52
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	943,885,510.00	
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	580,000,000.00	2,111,667,200.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	406,160,000.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	4,053,801,086.00	7,037,009,914.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас	-	7,037,009,914.00
Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	4,053,801,086.00	
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>16,694,929,708.36</b>	<b>21,379,265,440.65</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>16,477,289,203.49</b>	<b>20,830,159,417.33</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>16,477,289,203.49</b>	<b>20,830,159,417.33</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>5,346,787,956.00</b>	<b>5,812,081,307.00</b>
Цалин	5,325,727,956.00	5,807,757,307.00
Нэмэгдэл цалин	-	456,000.00
Урамшуулал	4,535,000.00	-
Гэрээтийн цалин	16,525,000.00	3,868,000.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>635,610,729.69</b>	<b>696,164,697.05</b>
Тэтгэврийн даатгалын шимтгэл	373,746,996.14	413,024,742.05
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	42,728,159.62	46,653,816.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	105,415,305.04	113,652,371.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	10,338,204.99	11,163,288.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	103,382,063.90	111,670,480.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>368,576,688.00</b>	<b>437,126,774.00</b>
Гэрэл цахилгааны зардал	166,599,177.00	201,660,593.00
Түлш, халаалтын зардал	116,087,457.00	120,339,117.00
Цэвэр, бохир усны зардал	85,890,054.00	115,127,064.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>346,684,791.64</b>	<b>321,471,006.00</b>
Бичиг хэргийн материал	66,214,495.00	61,667,441.00
Тээвэр, шатахууны зардал	49,416,050.00	34,417,331.00
Шуудан холбоо интернетийн төлбөр	8,940,085.64	9,279,479.00
Хог хаягдал устгах, цэвэрлэх	25,044,100.00	21,672,000.00
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	3,118,600.00	1,646,400.00
Аж ахуйн материал худалдан авах зардал	193,951,461.00	192,138,890.00
Бараа материал актасны зардал	-	649,465.00
<b>Нормативт зардал</b>	<b>5,826,368,446.66</b>	<b>6,028,511,275.61</b>
Хоол	449,128,546.35	393,311,659.90
Эм	5,377,239,900.31	5,635,199,615.71
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>109,337,899.19</b>	<b>324,387,220.74</b>
Багаж хэрэгсэл	379,900.00	7,357,452.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,706,460.00	1,135,000.00
Урсгал засвар	107,251,539.19	315,894,768.74
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>58,026,040.00</b>	<b>29,394,500.00</b>
Гадаад томилолтын зардал	10,248,500.00	-
Дотоод томилолтын зардал	47,777,540.00	29,394,500.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>63,534,128.00</b>	<b>83,638,311.20</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,195,418.00	70,200,000.00
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,900,000.00	-
Даатгалын үйлчилгээний төлбөр	68,400.00	305,660.00
Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	396,000.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	71,500.00	84,100.00

01  
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	6,880,440.00	8,681,251.20
Газрын төлбөр	3,652,000.00	3,652,000.00
Улсын мэдээллийн маягтын зардал	15,366,370.00	319,300.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,722,362,524.31</b>	<b>7,097,384,325.73</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	1,218,183,543.19	4,360,272,941.68
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	54,715,570.00	82,046,551.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,449,463,411.12	2,655,064,833.05
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>217,640,504.87</b>	<b>549,106,023.32</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	47,077,204.87	-
Засгийн газрын дотоод шилжүүлэг	47,077,204.87	-
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>170,563,300.00</b>	<b>480,575,800.00</b>
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	33,330,000.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	170,563,300.00	295,745,800.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	151,500,000.00
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>68,530,223.32</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	68,530,223.32
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>1,269,968,604.13</b>	<b>5,707,596,066.87</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>99,564.15</b>	<b>3,283.57</b>
Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	99,564.15	3,283.57
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>0.00</b>	<b>6,810,133.57</b>
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	6,810,133.57
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)</b>	<b>99,564.15</b>	<b>6,806,850.00</b>
<b>НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)</b>	<b>1,270,068,168.28</b>	<b>5,700,789,216.87</b>



**"ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ"-ИЙН  
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2017 оны 12 сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>15,168,135,219.42</b>	<b>18,955,792,908.94</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,850,634,633.42</b>	<b>2,093,252,865.00</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,850,634,633.42</b>	<b>2,093,252,865.00</b>
<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,396,338,325.00</b>	<b>2,093,252,865.00</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,214,043,794.00	1,897,302,800.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	182,294,531.00	195,950,065.00
Бусад орлого	454,296,308.42	
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>13,317,500,586.00</b>	<b>16,862,540,043.94</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>8,683,699,500.00</b>	<b>9,199,958,300.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,683,699,500.00	9,199,958,300.00
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>580,000,000.00</b>	<b>625,571,829.94</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		79,750,740.00
Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУБайгууллага	-	54,493,126.52
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	580,000,000.00	9,467,200.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	406,160,000.00
Урьд оны үлдэгдэлээс санхүүжих- Нэмэлт	-	75,700,763.42
<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>4,053,801,086.00</b>	<b>7,037,009,914.00</b>
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		7,037,009,914.00
Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	4,053,801,086.00	
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>14,762,299,191.42</b>	<b>18,785,721,708.94</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>14,762,299,191.42</b>	<b>18,785,721,708.94</b>
<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>14,762,299,191.42</b>	<b>18,785,721,708.94</b>
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	<b>5,176,526,593.80</b>	<b>5,821,435,955.85</b>
Үндсэн цалин	4,097,952,222.00	3,815,391,956.00
Нэмэгдэл		537,486,499.85
Унаа хоолны хөнгөлөлт	436,434,800.00	459,826,100.00
Үр дүнгийн урамшуулал	510,271,571.80	537,759,700.00
Гэрээт ажлын хөлс	131,868,000.00	470,971,700.00
<b>Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>615,528,800.00</b>	<b>687,981,500.00</b>
Тэтгэврийн даатгалын шимтгэл	615,528,800.00	687,981,500.00
<b>Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал</b>	<b>368,576,688.00</b>	<b>437,126,774.00</b>
Гэрэл цахилгааны зардал	166,599,177.00	201,660,593.00
Түлш, халаалтын зардал	116,087,457.00	120,339,117.00
Цэвэр бохир ус	85,890,054.00	115,127,064.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>251,855,815.64</b>	<b>2,229,851,360.00</b>
Бичиг хэрэг	12,085,000.00	7,601,840.00
Тээвэр, шатахуун	48,948,450.00	34,630,331.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,111,285.64	9,319,479.00
Ном, хэвлэл		
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	141,032,700.00	139,279,710.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,678,380.00	39,020,000.00
Аж ахуйн материал худалдан авах зардал		
<b>Нормативт зардал</b>	<b>6,228,253,783.51</b>	<b>6,612,424,033.63</b>
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,698,515,228.51	6,138,680,328.33
Хоол, хүнс	469,896,955.00	417,295,105.30
Нормын хувцас, зөөлөн эдлэл	54,841,600.00	56,648,600.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>334,710,007.00</b>	<b>177,586,361.00</b>
Багаж техник хэрэгсэл	217,805,905.00	28,013,601.00
Тавилга	53,887,795.00	25,085,800.00



Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	23,397,671.00	13,741,110.00
Урсгал засвар	39,618,636.00	110,745,850.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>58,026,040.00</b>	<b>29,424,500.00</b>
Гадаад албан томилолт	10,248,500.00	
Дотоод албан томилолт	47,777,540.00	29,424,500.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>65,031,958.00</b>	<b>101,507,911.20</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	34,195,418.00	70,200,000.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,900,000.00	
Даатгалын үйлчилгээ	68,400.00	305,660.00
Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	396,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	71,500.00	84,100.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,880,440.00	9,005,251.00
Газрын төлбөр	3,652,000.00	3,652,000.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	16,864,200.00	17,864,900.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,375,448,237.18</b>	<b>4,106,547,600.20</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	1,311,874,567.18	4,019,242,589.20
Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	63,573,670.00	87,305,011.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>293,341,268.29</b>	<b>581,635,713.06</b>
<b>Засгийн газрын дотоод шилжүүлэг</b>	<b>122,777,968.29</b>	<b>46,138,909.74</b>
Засгийн газрын дотоод шилжүүлэг	122,777,968.29	46,138,909.74
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>170,563,300.00</b>	<b>466,966,580.00</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	170,563,300.00	295,745,800.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		171,220,780.00
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>68,530,223.32</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг		68,530,223.32
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>405,836,028.00</b>	<b>170,071,200.00</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>406,136,028.00</b>	<b>170,071,200.00</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>406,136,028.00</b>	<b>170,071,200.00</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>406,136,028.00</b>	<b>170,071,200.00</b>
<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>406,136,028.00</b>	<b>170,071,200.00</b>
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	406,136,028.00	170,071,200.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>- 406,136,028.00</b>	<b>- 170,071,200.00</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>- 300,000.00</b>	<b>-</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	300,000.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		



**"ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ"-ИЙН  
АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨЛӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

2017 оны 12 сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2016 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>17,025,450,888.38</b>	<b>4,759,387,968.04</b>	<b>- 7,205,152,886.39</b>	<b>14,579,685,970.03</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>17,025,450,888.38</b>	<b>4,759,387,968.04</b>	<b>- 7,205,152,886.39</b>	<b>14,579,685,970.03</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			1,270,068,168.28	<b>1,270,068,168.28</b>
				-
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>17,025,450,888.38</b>	<b>4,759,387,968.04</b>	<b>- 5,935,084,718.11</b>	<b>15,849,754,138.31</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			1,697,719.90	<b>1,697,719.90</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>17,025,450,888.38</b>	<b>4,759,387,968.04</b>	<b>- 5,933,386,998.21</b>	<b>15,851,451,858.21</b>
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн		- 1,697,719.90		- <b>1,697,719.90</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн			5,700,789,216.87	<b>5,700,789,216.87</b>
				-
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>17,025,450,888.38</b>	<b>4,757,690,248.14</b>	<b>- 232,597,781.34</b>	<b>21,550,543,355.18</b>



**"ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ"-ИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2017 оны 12 сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө</b>			-	
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>18,984,228,500.00</b>	<b>18,330,221,079.00</b>	<b>654,007,421.00</b>	<b>97</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>18,984,228,500.00</b>	<b>18,330,221,079.00</b>	<b>654,007,421.00</b>	<b>97</b>
<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>18,490,781,700.00</b>	<b>17,794,724,275.68</b>	<b>696,057,424.32</b>	<b>96</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>5,733,178,900.00</b>	<b>5,733,178,899.85</b>	<b>0.15</b>	<b>100</b>
Үндсэн цалин	3,727,134,900.00	3,727,134,900.00	-	100
Нэмэгдэл	537,486,500.00	537,486,499.85	0.15	100
Унаа хоолны хөнгөлөлт	459,826,100.00	459,826,100.00	-	100
Урамшуулал	537,759,700.00	537,759,700.00	-	100
Гэрээт ажлын хөлс	470,971,700.00	470,971,700.00	-	100
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>687,981,500.00</b>	<b>687,981,500.00</b>	-	<b>100</b>
Тэтгэвэрийн даатгал	687,981,500.00	687,981,500.00	-	100
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>461,734,900.00</b>	<b>437,126,774.00</b>	<b>24,608,126.00</b>	<b>95</b>
Гэрэл цахилгаан	155,252,500.00	201,660,593.00	-	130
Түлш халаалт	180,606,900.00	120,339,117.00	60,267,783.00	67
Цэвэр бохир ус	125,875,500.00	115,127,064.00	10,748,436.00	91
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>209,673,500.00</b>	<b>209,673,500.00</b>	-	<b>100</b>
Бичиг хэрэг	5,811,700.00	5,647,200.00	164,500.00	97
Тээвэр шатахуун	17,850,000.00	17,227,111.00	622,889.00	97
Шуудан холбоо интернэтийн төлбөр	9,357,100.00	8,499,479.00	857,621.00	91
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутга	140,305,300.00	139,279,710.00	1,025,590.00	99
Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	36,349,400.00	39,020,000.00	-	107
<b>Нормативт зардал</b>	<b>6,709,306,300.00</b>	<b>6,501,644,032.63</b>	<b>207,662,267.37</b>	<b>97</b>
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,204,578,100.00	6,027,700,327.33	176,877,772.67	97
Хоол, хүнс	444,845,100.00	417,295,105.30	27,549,994.70	94
Нормын хувцас зөөлөн эдлэл	59,883,100.00	56,648,600.00	3,234,500.00	95
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>98,793,300.00</b>	<b>98,793,220.00</b>	<b>80.00</b>	<b>100</b>
Багаж техник хэрэгсэл	29,563,100.00	36,901,601.00	-	125
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	14,995,000.00	14,541,010.00	453,990.00	97
Урсгал засвар	54,235,200.00	47,350,609.00	6,884,591.00	87
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,435,400.00</b>	<b>5,100,500.00</b>	<b>334,900.00</b>	<b>94</b>
Гадаад албан томилолт				
Дотоод албан томилолт	5,435,400.00	5,100,500.00	334,900.00	94
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>107,910,600.00</b>	<b>99,333,660.00</b>	<b>8,576,940.00</b>	<b>92</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураам	78,408,000.00	70,200,000.00	8,208,000.00	90
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох			-	
Даатгалын үйлчилгээ	346,500.00	305,660.00	40,840.00	88
Тээврийн хэрэгслийн татвар	396,000.00	396,000.00	-	100
Тээврийн хэрэгслийн оношлогоо	84,100.00	84,100.00	-	100
Мэдээллийн технологийн зардал	6,831,000.00	6,831,000.00	-	100
Газрын төлбөр	3,960,000.00	3,652,000.00	308,000.00	92
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	17,885,000.00	17,864,900.00	20,100.00	100
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,476,767,300.00</b>	<b>4,021,892,189.20</b>	<b>454,875,110.80</b>	<b>90</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	4,476,767,300.00	4,021,892,189.20	454,875,110.80	90
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>493,446,800.00</b>	<b>535,496,803.32</b>	<b>- 42,050,003.32</b>	<b>109</b>
<b>Засгийн газрын дотоод шилжүүлэг</b>		<b>68,530,223.32</b>	<b>- 68,530,223.32</b>	
Засгийн газрын дотоод шилжүүлэг		68,530,223.32	-	
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>493,446,800.00</b>	<b>466,966,580.00</b>	<b>26,480,220.00</b>	<b>95</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	310,131,800.00	295,745,800.00	14,386,000.00	95
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	183,315,000.00	171,220,780.00	12,094,220.00	93
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>18,984,228,500.00</b>	<b>18,330,221,079.00</b>	<b>654,007,421.00</b>	<b>97</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>9,214,344,300.00</b>	<b>9,199,958,300.00</b>	<b>14,386,000.00</b>	<b>100</b>
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,214,344,300.00	9,199,958,300.00	14,386,000.00	100
<b>НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>7,033,816,700.00</b>	<b>7,037,009,914.00</b>	<b>- 3,193,214.00</b>	<b>100</b>
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	7,033,816,700.00	7,037,009,914.00	-	100
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>2,736,067,500.00</b>	<b>2,093,252,665.00</b>	<b>642,814,835.00</b>	<b>77</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,516,067,500.00	1,897,602,800.00	618,464,700.00	75
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	220,000,000.00	195,950,065.00	24,049,935.00	89
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>				
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>				
<b>АЖИЛЛАГСАД БҮГД</b>	<b>465.00</b>	<b>465.00</b>	-	
Гүйцэтгэх ажилтан	455.00	455.00	-	
Үйлчлэх ажилтан	10.00	10.00	-	

01  
Төрийн аудитын байгууллага  
ЗӨРЧИЙН  
САНАЛ ДҮГНЭГ

**"ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ"-ИЙН 2017 ОНЫ НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2017 оны 12 сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө</b>			-	
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	579,432,920.20	-	579,432,920.20
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	579,432,920.20	-	579,432,920.20
<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	-	579,432,920.20	-	579,432,920.20
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	88,257,056.00	-	88,257,056.00
Үндсэн цалин		88,257,056.00	-	88,257,056.00
Нэмэгдэл			-	
Унаа хоолны хөнгөлөлт			-	
Урамшуулал			-	
Гэрээт ажлын хөлс			-	
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	-	-	
Тэтгэвэрийн даатгал			-	
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	-	-	
Гэрэл цахилгаан			-	
Түлш халаалт			-	
Цэвэр бохир ус			-	
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	20,177,860.00	-	20,177,860.00
Бичиг хэрэг		1,954,640.00	-	1,954,640.00
Тээвэр шатахуун		17,403,220.00	-	17,403,220.00
Шуудан холбоо интернэтийн төлбөр		820,000.00	-	820,000.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал			-	
Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс			-	
<b>Нормативт зардал</b>	-	129,630,001.00	-	129,630,001.00
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		129,630,001.00	-	129,630,001.00
Хоол, хүнс			-	
Нормын хувцас зөөлөн эдлэл			-	
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	227,564,741.00	-	227,564,741.00
Багаж техник хэрэгсэл		76,629,237.00	-	76,629,237.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		87,540,263.00	-	87,540,263.00
Урсгал засвар		63,395,241.00	-	63,395,241.00
<b>Томилолт, зочны зардал</b>	-	24,324,000.00	-	24,324,000.00
Гадаад албан томилолт				
Дотоод албан томилолт		24,324,000.00	-	24,324,000.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	-	2,174,251.20	-	2,174,251.20
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж			-	
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох			-	
Даатгалын үйлчилгээ			-	
Тээврийн хэрэгслийн татвар			-	
Тээврийн хэрэгслийн оношлогоо			-	
Мэдээллийн технологийн зардал		2,174,251.20	-	2,174,251.20
Газрын төлбөр			-	
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх			-	
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	87,305,011.00	-	87,305,011.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага		87,305,011.00	-	87,305,011.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	46,138,909.74	-	46,138,909.74
<b>Засгийн газрын дотоод шилжүүлэг</b>		-	-	
Засгийн газрын дотоод шилжүүлэг			-	
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	46,138,909.74	-	46,138,909.74
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж			-	
Засгийн газрын дотоод шилжүүлэг		46,138,909.74	-	46,138,909.74
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	75,700,763.42	-	75,700,763.42
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	-	
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			-	
<b>НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	-	
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих			-	
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	75,700,763.42	-	75,700,763.42
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			-	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих			-	
Урьд оны үлдэгдлээс санхүүжих		75,700,763.42	-	75,700,763.42
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		549,871,066.52	-	549,871,066.52
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	79,750,740.00	-	79,750,740.00
Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУ	-	54,493,126.52	-	54,493,126.52
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн	-	9,467,200.00	-	9,467,200.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орл	-	406,160,000.00	-	406,160,000.00
Хөрөнгө оруулалтын санхүүжилт				
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-			
<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-			
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>				
<b>АЖИЛЛАГСАД БҮГД</b>	465.00	465.00		
Удирдах ажилтан				
Гүйцэтгэх ажилтан	455.00	455.00		
Үйлчлэх ажилтан	10.00	10.00		
Гэрээт ажилтан				

01
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын байгууллага